

## ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ ( цаашид “ёс зүйн хэм хэмжээ” гэх) нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль бусад холбогдох хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон энэхүү ёс зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдоно.

1.2 Эрүүл мэндийн байгууллага нь ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж, эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага тооцож ажиллана.

1.3 Ёс зүйн хэм хэмжээ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5-д заасан мэргэжилтнүүдэд хамаарна.

1.4 Шаардлагатай тохиолдолд энэхүү ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн төрөлжсөн мэргэжлийн онцлогийг тусгасан ёс зүйн нэмэлт хэм хэмжээг тухайн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн нийгэмлэг боловсруулж, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулан, мөрдүүлж болно.

1.5 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа шударга ёс, хууль дээдлэх, тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах, хариуцлага хүлээх, үйлчлэх зарчмыг баримтална.

### Хоёр. Нэр томъёоны тайлбар

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд хэрэглэгдсэн зарим нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

**Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй** гэж эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг;

**Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ** гэж эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон журмыг;

**Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн горим** гэж эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, нийгэмтэй болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмыг;

**Эмнэлгийн мэргэжилтэн** гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5 заалтын дагуу;

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ** гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.3 заалтаар тодорхойлсон ойлголтыг;

**Эрүүл мэндийн байгууллага** гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.4 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

**Эмнэлгийн яаралтай тусламж** гэж амь насанд аюултай аливаа эмгэгийг оношлох, эмчлэх сэхээн амьдруулах цогц үйл ажиллагааг;

**Эмнэлгийн хязгаарлагдмал нөөц** гэж эмнэлгийн тухайн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм тарианы хангалтгүй байдлыг ойлгоно.

**Биологийн идэвхит бүтээгдэхүүн** гэж хүний бие махбодийн үйл ажиллагааг дэмжих, шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчлэл бүхий бүтээгдэхүүнийг;

**Бэлэг** гэж “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3.1.9 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

**Бэлгийн дарамт** гэж “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн 4.1.7 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

**Давуу байдал** гэж “Авлигын эсрэг” хуулийн 3.1.4 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

**Давхар харилцаа** гэж эмч-үйлчлүүлэгчийн харилцаанаас гадуур бусад харилцаа (тэднийг өөрийн эрхшээлд оруулах замаар хувийн харилцаанд орох, тухайлбал эмнэлгийн мэргэжилтэн өөрийн давуу байдлаа ашиглан үйлчлүүлэгчийг хувийн зорилгод ашиглах);

**Үйлчлүүлэгч** гэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахтай холбоотой харилцаанд оролцогч иргэнийг;

**Үйлчлүүлэгчийн нууц** гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн яриа, өвчний түүх, үзлэг, шинжилгээ, өвчний хэтийн байдалд үнэлгээ өгсөн тэмдэглэл зэргээс олж авсан “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн 4.2.2 дах заалтад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийг;

**Хандив** гэж “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3.1.8 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

**Хөндлөнгийн саадгүй орчин** гэж үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн хүн (бусад эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч) саад болохооргүй өрөө тасалгаа эсвэл зориулалтын хаалтаар тусгаарлагдсан өрөө тасалгаанд тусламж үйлчилгээ үзүүлэхийг;

**Үл ялгаварлан гадуурхах** гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна төрх байдал, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, хүн амын тодорхой бүлэгт харъяалагдах байдлаар алагчлахгүй байхыг;

### **Гурав. Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээ**

3.1 Эмнэлгийн мэргэжилтэн нь шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төгс үзүүлэхэд өөрийн мэдлэг, чадвар, туршлагыг бүрэн зориулж, хүнлэг энэрэнгүй, шударга ёсны зарчмыг баримтална.

3.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үл ялгаварлан хүн бүрт тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

3.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг мөрдөж ажиллана.

3.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь мэдлэг, чадвараа байнга дээшлүүлэн, шаардлагатай үед бусад мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, тэдэнтэй мэдлэг, ур чадвараа харилцан солилцож, шинжлэх ухааны ололт, нээлтийг ажилдаа бүтээлчээр нэвтрүүлэхийг эрмэлзэж ажиллана.

3.5 Эмнэлгийн мэргэжилтэн нь био-анагаахын ёс зүйн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөнө.

3.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь аливаа дүгнэлт, шийдвэрийг бодит байдалд тулгуурлан үнэн зөв гаргана.

3.7 Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан болсноор эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн үүрэг хариуцлага нь өөрчлөгдөхгүй.

3.8 Эмнэлгийн удирдах ажилтан нь ёс зүйн дараах нэмэлт үүргийг хүлээнэ.

3.8.1 Хариуцсан нэгж, байгууллагын түвшинд үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8.2 Эмнэлгийн хязгаарлагдмал нөөцийг шударгаар хуваарилах тухай байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлнэ.

3.8.3 Байгууллагын хэмжээнд ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ёс зүйн хяналтын хороо болон салбар хороо, хэсгийн хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

3.8.4 Энэ дүрмийн 7.1-д заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан эмчийн хүсэлтийг хүлээн авч, шалган, нэн даруй шийдвэрлэнэ.

3.9 Мэдлэг, ур чадвараа хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх;

3.10 Эмнэлгийн байгууллага, эмнэлгийн бусад мэргэжилтний нэр төр, мэргэжлийн ур чадвар болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой аливаа мэдээллийг санамсаргүй буюу санаатайгаар хөндлөнгийн хүмүүст болон тэдний дэргэд дэлгэн ярих, шүүмжлэн ярихгүй;

3.11 Мэргэжил, мэргэшсэн давуу байдлаа ашиглан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, саад тотгор учруулах, санаатайгаар олноороо бүлэглэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, стандартыг алдагдуулахгүй байх;

3.12 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн амбулаторийн карт, өвчний түүх, эрүүл мэнд, эмчилгээ, үйлчилгээний талаарх тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх, эсвэл хуурамч бичиг баримтад гарын үсэг зурах, үйлчлүүлэгчийн эрүүл мэндтэй холбоотой бичиг баримтыг нөхөж бичих, засварлах, устгах, хуудас солихгүй;

3.13 Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бичиг баримтыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу ашиглуулахгүй;

3.14 Үйлчлүүлэгчид урьдчилан мэдээлж, зөвшөөрөл авалгүйгээр төлөвлөгөөт мэс заслын явцад эмчийг солих нь ёс зүйд нийцэхгүй;

3.15 Хэвтэн эмчлүүлэгчдэд яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд эмчлэгч эмчийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр эмч үзлэг хийх, тусламж үйлчилгээтэй холбоотой зааварчилгаа өгөхгүй байх;

3.16 Шаардлагагүй тусламж үйлчилгээг зааварчлах, үзүүлэхгүй байх;

3.17 Үйлчлүүлэгч мэс засал хийлгэсэн, эсвэл эмнэлэгт нас барсан тохиолдолд өөрийнх нь болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний эд эрхтнийг авах, зарах, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй бөгөөд ийм үйл ажиллагаанд оролцохгүй, энэ талаар зааварчилгаа өгөхгүй;

3.18 Үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой байхад хувийн ашиг сонирхлын үүднээс өөр эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхийг албадах, үйлчилгээний тодорхой хувилбарыг үйлчлүүлэгчид тулгах нь ёс зүйд үл нийцнэ;

3.19 Үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр түүнийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танигдахуйц байдлаар харуулах буюу бусад хэлбэрээр сурталчилгаанд оруулахгүй;

3.20 Үйлчлүүлэгчийг илт төөрөгдүүлж, худал ташаа мэдээлэл бүхий сурталчилгаа явуулахгүй;

3.21 Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, үр дүн нь тодорхойгүй, стандартын бус, чанарын баталгаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг дэмжиж сурталчлах, түүнийг оношлогоо эмчилгээнд хэрэглэхгүй, зарж борлуулах, түгээх, үйлчилгээг үйлчлүүлэгчид санал болгож, сурталчлахгүй байх;

3.22 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр анагаахын болон шинжлэх ухааны туршилтанд хамруулахгүй байх;

3.23 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эрүүл мэндийн байгууллага, эмчээ сонгох эрхээ эдэлж, сонголт хийхэд нь хувийн ашиг сонирхлын үүднээс хандаж нөлөө үзүүлэхгүй байх;

3.24 Эмнэлгийн мэргэжилтэн нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрүүдэн шүүх, тарчлаан зовоох, харгис хэрцгий харилцах, нэр төрийг нь доромжлох, басамжлах аливаа хэлбэрийг нуун дарагдуулах ба өөрөө оролцох;

3.25 Эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснийхээ төлөө үйлчлүүлэгчээс авлига, хууль бус шан харамж, хандив, бэлэг, албан бус төлбөр авахгүй ба үйлчлүүлэгчтэй давхар харилцаанд орохгүй байх,

3.26 Үйлчлүүлэгч болон хамтран ажиллагсдыг бэлгийн дарамтанд оруулахгүй байх;

3.27 Удирдах ажилтан болон эмнэлгийн мэргэжилтэн давуу байдлаа ашиглан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үйлчлүүлэгч, хамт олон, нийгэмд хор хохирол учруулахуйц үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, бусдыг татан оролцуулахгүй байх;

3.28 Удирдах ажилтан нь эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс оролцох, зааварчлах, тулган шаардахгүй байх.

### **Дөрөв. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцах горим**

4.1 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид хүнлэг энэрэнгүй хандаж, тэдний хууль ёсны эрх, нэр төрийг хүндэтгэж харилцана.

4.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээг хөндлөнгийн саадгүй орчинд үзүүлнэ.

4.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн өвчний онош, тавилангийн талаар болон аливаа өвчин эмгэгийн мөн чанар, шалтгаан, оношилгоо, эмчилгээний аргууд, тэдгээрийн үр дүн, эрсдэл, хүндрэл, өөрийн болон тухайн байгууллагын бодит чадавхи, өөр бусад боломжит хувилбарын талаар болон бусад шаардлагатай үнэн зөв мэдээллийг үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-д энгийн, ойлгомжтой үгээр тайлбарлан, шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ.

4.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн биеийн байдлыг сайжруулах, сэтгэл санааны дэм үзүүлэх, зовлон зүдгүүрийг багасгах, хөнгөлөх, аливаа нэмэлт, зовиур шаналгаа үүсгэхгүй, оновчтой тусламж үйлчилгээ үзүүлэхийг эрмэлзэж ажиллана.

4.5 Эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэхдээ яаралтай тусламжаас бусад тохиолдолд эхэнд ирсэн нь эхэлж үйлчлүүлэх буюу тэгш эрхийг хангасан хуваарилалтын зарчмыг баримтална.

4.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчээс дараах тохиолдолд шийдвэрийг бичгээр авна.

4.6.1 Тусламж үйлчилгээнээс үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) татгалзсан;

4.6.2 Амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх;

4.6.3 Мэс ажилбар, мэс засал хийх тохиолдол бүрт (гоо сайхны мэс ажилбар, мэс засал хамаарна);

4.6.4 Донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар хийх (хүлээн авагч ба донороос тус тусад нь зөвшөөрөл авна).

4.7 Хэрэв үйлчлүүлэгч насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй бол шийдвэрийг түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-өөс бичгээр авна.

4.8 Эмнэлгийн мэргэжилтэн нь дараахь тохиолдолд үйлчлүүлэгч, түүний ар гэрийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргаж болно:

4.8.1 Үйлчлүүлэгч сэтгэцийн хүнд эмгэгийн улмаас зөвшөөрөл өгөх чадваргүй үед яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх нь ноцтой үр дагаварт хүргэх нь илэрхий;

4.8.2 Өвчний талаарх мэдээлэл нь үйлчлүүлэгчид сэтгэл зүйн хүнд цохилт өгөх, түүнээс үүдсэн ноцтой үр дагавар учруулах эрсдэлтэй.

4.9 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд түүнийг амьд сэрүүн байх хугацаанд төдийгүй нас барсных нь дараа ч чандлан хадгална.

4.10 Зайлшгүй шаардлагаар өөрийн хувийн өмчийн эсвэл үйл ажиллагааны ашгаас нь хувь хүртдэг эмнэлгийн байгууллагадаа үйлчлүүлэгчийг илгээх бол энэ тухай үйлчлүүлэгчид мэдээлэхийн зэрэгцээ ижил төрлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бусад мэргэжилтэн, байгууллагын талаар бүрэн мэдээлэл өгнө.

4.11 Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал эрс муудсан буюу үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд энэ тухай түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-д үнэн бодитоор мэдээлэх үүргийг зөвхөн эмч хүлээнэ.



4.12 Амьдралын төгсгөлийн шатанд орсон буюу эдгэрэшгүй, тавилан тодорхойгүй өвчтэй үйлчлүүлэгчийн хувьд сэтгэл зүйн бэлтгэлээс хамаарч мэдээллийг хэдийд, ямар байдлаар бүрэн өгөхийг шийднэ.

4.13 Үйлчлүүлэгчийн амьдрах хугацааг уртасгахад чиглэсэн арга хэмжээ цаашид үр дүнгүй нь илэрхий тохиолдолд түүний биеийн байдлыг хөнгөвчлөх зорилгоор өвдөлт, зовиур шаналгааг багасган, амар тайван байдлыг хангахад эмчилгээ, үйлчилгээг чиглүүлж болно.

4.14 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид хүчирхийллийн (бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны г.м) шинж тэмдэг байгаа эсэхийг байнга анхаарч, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлж, таслан зогсоох, давтагдахаас урьдчилан сэргийлж ажиллана.

4.15 Эмнэлгийн мэргэжилтэн нь ял эдэлж буй хүнд шүүхийн шийдвэрээс үл хамааран, тусламж, үйлчилгээг тэгш, чанартай үзүүлнэ.

#### **Тав. Эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцааны горим**

5.1 Эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцаа нь нэг нэгнийгээ дэмжсэн, харилцан хүндэтгэсэн, хамтын ажиллагааны зарчимд үндэслэнэ.

5.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжил нэгт нөхөдтэйгээ чөлөөт, шударгаар өрсөлдөнө.

5.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжил нэгт нөхөд, эмнэлгийн бусад мэргэжилтний эрхийг хүндэтгэн, нөхөрсөг, шударгаар хамтран ажиллах ба ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргах, үйлчлүүлэгчид хайхрамжгүй хандах, хууран мэхлэх, залилахтай эвлэрэхгүй байхын зэрэгцээ эдгээр үйлдлээс өөрийгөө болон мэргэжил нэгтнээ сэргийлэн ажиллана.

5.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа өөрийн санаачлагаар буюу үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн хүсэлтээр бусад эмчийн зөвлөгөө, тусламжийг авч болно.

5.5 Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргах үйл явцад эмч нарын хооронд санал зөрөөтэй байдал үүсвэл эцсийн шийдвэрийг эмчлэгч эмч гаргана. Эмч нарын зөвлөлгөөн хийсэн тохиолдолд зөвлөлгөөний шийдвэрийг дагана.

5.6 Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн талаарх өөрт байгаа бүх мэдээллийг дараах эмнэлгийн мэргэжилтнүүдэд саадгүй өгч болох ба үүний тулд үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-өөс зөвшөөрөл авах шаардлагагүй:

5.6.1 өөрийг нь шууд удирдан ажилладаг эмнэлгийн мэргэжилтэн;

5.6.2 зөвлөх мэргэжилтэн;

5.6.3 тухайн үйлчлүүлэгчийн эмчилгээний асуудлыг шийдэхэд шууд оролцож буй эмнэлгийн мэргэжилтнүүд;

5.6.4 хуулиар олгогдсон эрх бүхий бусад хүмүүс.

5.7 Яаралтай тусламж шаардагдсан үед үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) нэгэн зэрэг хэд хэдэн эмч дуудаж, ирсэн тохиолдолд хэн нэгнээр нь үйлчлүүлэх талаар онцлон хүсэлт гаргаагүй бол түрүүлж ирсэн эмч дараагийн мэргэжилтэнд шилжүүлэх хүртэл тусламж үзүүлнэ.

5.8 Сувилагч нь анагаах ухаан, сувилахуйн стандартад нийцээгүй үйлчилгээ, үйлдлийг эмчийн зааврын дагуу гүйцэтгэхээс татгалзах эрхтэй ба хэрэв ийм үйлчилгээ, үйлдэл хийхийг шаардсан, зааварласан тохиолдолд шууд харъяалах дээд албан тушаалтанд мэдээлнэ.

### **Зургаа. Эмнэлгийн мэргэжилтэн нийгэмтэй харилцах горим**

6.1 Эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол Улсын Үндсэн хууль болон эрүүл мэндийн тухай хууль тогтоомжууд, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах

талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, өрх бүл, иргэдтэй хамтран ажиллана.

6.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэрээс үл хамааран өөрийн хувийн ашиг сонирголоос нийгэм, олон нийтийн эрх ашгийг дээгүүрт тавина.

6.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь олон улсын болон халамж, буяны байгууллагууд, сайн санаат иргэдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зориулан өгсөн тусламжийг зориулалтаар нь ашиглана.

6.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, интернэт, телефон утас бусад дам харилцааны хэлбэрээр дамжуулан нийтэд зөвлөгөө өгч буй тохиолдолд эмчилгээ оношлогооны аргыг шууд зааварчлахгүй. Харин тухайн өвчний талаарх ерөнхий мэдээлэл, тусламж үйлчилгээг авахад шаардлагатай лавлагаагаар хангаж болно.

6.5 Эмнэлгийн мэргэжилтэн өөрийн үйл ажиллагааг сурталчилж болно. Сурталчилгаа нь зөвхөн эмнэлгийн мэргэжилтний мэргэжил эзэмшсэн сургууль, зэрэг цол, ажлын дадлага туршлага, үйл ажиллагаа явуулдаг байршил, тусламж үйлчилгээ үзүүлэх хуваарьтай холбоотой үнэн зөв мэдээллийг агуулах ба мэргэжлийн нэр томъёо хэрэглэхгүйгээр энгийн, ойлгомжтой үг хэллэг хэрэглэнэ.

6.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүний болон оношлогоо, эмчилгээний бусад аргатай холбоотой ташаа, бүрэн бус, ойлгомжгүй, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, удирдамжид нийцээгүй мэдээлэл бүхий сурталчилгааны талаар холбогдох байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

### **Долоо. Эмнэлгийн мэргэжилтэн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах**

7.1 Үйлчлүүлэгчийн болон түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүд, найз нөхдийн зүгээс эмнэлгийн мэргэжилтэнтэй ёс бусаар харилцах, бие махбодид нь халдах, заналхийлэх, айлган сүрдүүлснээс тусламж, үйлчилгээг цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болж мэргэжлийн алдаа гаргаж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд

тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн татгалзах болсон үндэслэлээ үйлчлүүлэгч, өөрийн байгууллагын удирдлагад бичгээр мэдэгдэх бөгөөд дараагийн эмнэлгийн мэргэжилтэн тусламж үйлчилгээг бүрэн хариуцан авах хүртэл үүрэгт ажлаа үргэлжлүүлнэ.

7.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн шаардсан тусламж үйлчилгээг нотолгоо, үндэслэлгүй гэж үзвэл татгалзаж болно.

### **Найм. Ёс зүйн хэм хэмжээг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага**

8.1 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргасан нь зохих журмын дагуу хийсэн шалгалтаар тогтоогдсон, Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хорооны болон салбар хорооны шийдвэрийг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтнүүдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгч нь дараах эрхтэй.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна төрх байдал, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, хүн амын тодорхой бүлэгт харъяалагдах байдлаас үл хамааран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй авах;
2. Өөрийн эрүүл мэндийн байдал болон эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаврын талаар мэдээлэл авч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харилцан санал солилцох, тайлбар авах;
3. Өөрийн эрүүл мэндийн талаарх нууцаа хамгаалуулах;
4. Эмчээ сонгох, тусламж үйлчилгээний явцад эмчлэгч эмчээ солих санал тавих;
5. Эмчийн зөвлөсөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эсэхийг өөрөө шийдэх, нийгэмд аюултай халдварт өвчтэй, сэтгэцийн хувьд өөрийгөө хянах чадваргүй болсноос бусад тохиолдолд эмчийн санал болгосон аливаа оношлогоо, эмчилгээг хийлгэхээс татгалзах;
6. Хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний талаар холбогдох байгууллагад мэдээлэх, өргөдөл, гомдол гаргах;
7. Төрөлжсөн мэргэжлийн болон ижил мэргэжлийн бусад эмчид үзүүлэх талаар эмчлэгч эмчид хүсэлт тавих;
8. Анагаахын болон шинжлэх ухааны судалгаа болон туршилтад оролцохоос татгалзах.

Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгч нь дараах үүрэгтэй.

1. Өөрийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх;
2. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд, бусад үйлчлүүлэгчийг хүндэтгэн харилцаж, тухайн эмнэлгийн байгууллагын дотоод журам, дүрмийг дагаж мөрдөх;
3. Өөрийн эрүүл мэндийн талаар эмнэлгийн мэргэжилтэнд шаардлагатай мэдээллийг үнэн зөв, бүрэн өгөх;
4. Эмчилгээний заавар, дэглэмийг чанд сахих ба ийнхүү сахиж биелүүлэхэд бэрхшээл учирвал холбогдох эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлж, учрыг тайлбарлах;
5. Эмчилгээний заавар, дэглэмийг баримтлахаас татгалзсан бол гарч болох сөрөг үр дагавар, хүндрэлийн хариуцлагыг өөрөө хүлээх тухайгаа бичгээр баталгаажуулах;
6. Хууль, дүрмээр зөвшөөрөгдсөн төлбөртэй тусламж үйлчилгээ авсан бол үйлчилгээний төлбөрийг төлөх.

Маягт 1

МЭС ЗАСАЛ/МЭС АЖИЛБАР ХИЙЛГЭХ  
ТУХАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

(Өвчтөний түүх/иргэний эрүүл  
мэндийн дэвтэрт хавсаргана)

А/ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Санал болгож буй мэс засал/мэс ажилбарын нэр:

.....  
.....

Санал болгож буй мэс засал/мэс ажилбар (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ын үр дүн (эмнэл зүйн туршлагын дүн, нотолгоонд тулгуурлан бүрэн эдгэрэлт, сайжралт, эндэгдэл, хүндрэлийн магадлалыг хувиар илэрхийлэн ойлгомжтойгоор тайлбарлана):

.....  
.....

Гарч болох эрсдлүүд (эрсдэлүүдийг нэг бүрчлэн дурьдана):

.....  
.....

Гарч болох хүндрэлүүд (хүндрэлүүдийг нэг бүрчлэн дурьдана):

.....  
.....

Тухайн мэс засал/мэс ажилбарын үед хийгдэж болох нэмэлт ажилбарууд (ажилбаруудыг нэг бүрчлэн дурьдана):

.....  
.....

Тухайн мэс засал/мэс ажилбар (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ыг орлуулж болох эмчилгээний бусад аргууд (бусад аргуудыг дурьдана):

.....  
.....

Санал болгож буй мэс засал/мэс ажилбарын давуу тал:

.....  
.....

Санал болгож буй мэс засал/мэс ажилбарын үед хийгдэх мэдээгүйжүүлэлт:

Ерөнхий, нугасны мэдээ алдуулалт, хэсгийн мэдээ алдуулалт, тайвшруулах (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)

Үйлчлүүлэгчээс тавьсан асуулт:

.....  
.....

Дээрх асуултын хариулт (товч):

.....  
.....

Эмчтэй холбоо барих утас: .....

Би үйлчлүүлэгчдээ дээрх мэдээллүүдийг дэлгэрэнгүй, энгийн ойлгомжтой хэллэгээр тайлбарлаж өгсөн болно.

Эмчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
нэр

**Б/ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ:**

- Эмчийн санал болгож буй мэс засал/мэс ажилбар(аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ыг дээрхи мэдээ алдуулалтаар хийлгэхийг **БИ ЗӨВШӨӨРЧ БАЙНА**. Түүнчлэн гэмтсэн эд, эрхтний хэсэг болон эд эрхтнийг журмын дагуу устгахыг уг эмнэлэгт зөвшөөрч байна.
- Мэс засал/мэс ажилбар(аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ын үр дүн, гарч болох хүндрэл, эрсдэл, нэмэлт ажилбарууд, орлуулж болох эмчилгээний талаар **БИ ТОДОРХОЙ МЭДЭЭЛЭЛ АВСАН БОЛНО**.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
нэр

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
Нэр

Үйлчлүүлэгчтэй холбоотой эсэх: \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:



[ ] Насанд хүрээгүй

[ ] Ухаангүй

[ ] Сэтгэцийн эмгэгтэй

[ ] Бусад (тайлбарлана уу).....

Хэрэв өвчтөн жирэмсэн тохиолдолд;

Миний эхнэрийн хийлгэхээр зөвшөөрсөн мэс ажилбар/мэс заслын хагалгаа(аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ыг би зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
Нэр

Хэрэв нөхөр (асран хамгаалагч/харгалзан дэмжигч) нь зөвшөөрөөгүй бол тайлбарлана уу.

.....  
.....  
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудасны загварыг 2 хувь үйлдсэн болно.

огноо: \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_

Маягт 2

АМЬ НАС/ЭРҮҮЛ МЭНДЭД ЭРСДЭЛТЭЙ ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

(Өвчтөний түүх/иргэний эрүүл  
мэндийн дэвтэрт хавсаргана)

А/ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Санал болгож буй оношилгооны ажилбар/эмчилгээ:

.....  
.....

Санал болгож буй оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ний үр дүн (эмнэл зүйн туршлагын дүн, нотолгоонд тулгуурлан бүрэн эдгэрэлт, сайжралт, эндэгдэл, хүндрэлийн магадлалыг хувиар илэрхийлэн ойлгомжтойгоор тайлбарлана):

.....  
.....

Гарч болох эрсдэлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....  
.....

Гарч болох хүндрэлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....  
.....

Тухайн оношилгооны ажилбар/эмчилгээний үед хийгдэж болох нэмэлт ажилбаруудыг нэг бүрчлэн дурьдана:

.....  
.....

Тухайн оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ыг орлуулж болох эмчилгээний бусад аргуудыг дурьдана:

.....  
.....

Санал болгож буй оношилгооны ажилбар/эмчилгээний давуу тал:

.....  
.....  
Санал болгож буй оношилгооны ажилбар/эмчилгээний үед хийгдэж болох мэдээгүйжүүлэлт:

- Ерөнхий
- Нугасны мэдээ алдуулалт
- Хэсгийн мэдээ алдуулалт
- Тайвшруулах

Үйлчлүүлэгчээс тавьсан асуулт:

.....  
.....

Дээрх асуултын хариулт (товч):

.....  
.....

Эмчтэй холбоо барих утас: .....

Би үйлчлүүлэгчдээ дээрх мэдээллүүдийг дэлгэрэнгүй, энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлаж өгсөн болно.

Эмчийн гарын үсэг \_\_\_\_\_ /..... /  
нэр

Б/ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ:

Надад шаардлагатай оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ний талаар эмчийн өгсөн мэдээллүүдийг БИ ОЙЛГОСОН. Иймд

.....  
.....

хийлгэхийг ЗӨВШӨӨРЧ БАЙНА.

Эмчийн санал болгосон оношилгооны ажилбар/эмчилгээ(зурах)-аас гадна

.....  
.....

зэрэг нэмэлт ажилбар болон орлуулах эмчилгээ нь зөвхөн миний амь насыг аврах болон миний биеийн байдлыг муудахаас сэргийлэхийн тулд хийнэ гэдгийг БИ ОЙЛГОЖ БАЙНА.

Харин дараах ажилбаруудыг ХИЙЛГЭХИЙГ БИ ЗӨВШӨӨРӨХГҮЙ БАЙНА.

.....  
.....  
Үйлчлүүлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
нэр

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:  
Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
нэр

Үйлчлүүлэгчтэй холбоотой эсэх: \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан

[ ] Насанд хүрээгүй

[ ] Ухаангүй

[ ] Сэтгэцийн эмгэгтэй

[ ] Бусад (тайлбарлана уу).....

Хэрэв өвчтөн жирэмсэн тохиолдолд;

Миний эхнэрийн хийлгэхээр зөвшөөрсөн мэс заслын хагалгааг би мөн зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
Нэр

Хэрэв нөхөр (асран хамгаалагч, харгалзан дэмжигч) нь зөвшөөрөөгүй бол тайлбарлана  
уу:

.....  
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудасны загварыг 2 хувь үйлдсэн болно.

огноо: \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

Маягт 3

ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ЭМНЭЛГЭЭС ГАРАХ ТУХАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

(Өвчтөний түүхэнд хавсаргана).

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ би эмчийн зөвшөөрсөн хугацаанаас өмнө эмнэлгээс гарах нь эмчлэгч эмч болон эмнэлгийн удирдлагын зааврыг дагаж мөрдөөгүй гэдгийг ойлгож байна.

Миний эмнэлгээс гарч буй шалтгаан:

.....  
.....

Энэ мөчид эмнэлгээс гарснаар миний биед гарч болох хүндрэлүүдийн талаар дараах МЭДЭЭЛЛИЙГ БИ АВСАН БОЛНО.

.....  
.....

Дээр дурдсан хүндрэлийн жагсаалт нь бүрэн бус гэдгийг БИ ОЙЛГОСОН бөгөөд хэрвээ би хүссэн тохиолдолд нэмэлт мэдээлэл авч болно гэдгийг МЭДЭЖ БАЙНА.

Энэ мөчид эмнэлгээс гарч, тусламж үйлчилгээ зогссоноос болж гарах үр дагаварт эмчлэгч эмч, эмнэлгийг буруутгахгүй.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
нэр

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
нэр

Үйлчлүүлэгчтэй холбоотой эсэх: \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:

[ ] Ерөнхий

[ ] Нугасны мэдээ алдуулалт

[ ] Хэсгийн мэдээ алдуулалт

[ ] Тайвшруулах

[ ] Бусад (тайлбарлана уу).....

Хэрэв өвчтөн жирэмсэн тохиолдолд:

Миний эхнэр эмчийн зөвшөөрсөн хугацаанаас өмнө эмнэлгээс гарахыг би зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../

нэр

Хэрэв нөхөр (асран хамгаалагч/харгалзан дэмжигч) нь зөвшөөрөөгүй бол тайлбарлана уу:

.....

.....

Энэхүү зөвшөөрлийн хуудасны загварыг 2 хувь үйлдсэн болно.

огноо: \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_

Маягт 4

ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТУХАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

(Өвчтөний түүх/иргэний эрүүл  
мэндийн дэвтэрт хавсаргана)

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ би дараах эмчилгээ  
үйлчилгээ авах хүсэлтэй байна. (ямар тусламж, үйлчилгээ авах саналтай байгаагаа  
дэлгэрэнгүй бичнэ. Үүнд: эмийн эмчийлгээ, мэс ажилбар, гоо сайхны хагалгаа зэрэг бүх  
үйлчилгээ хамаарна)

.....  
.....

Миний зүгээс уг эмчилгээ, үйлчилгээг хийлгэх гэж буй шалтгаан:

.....  
.....

Өөрийн хүсэлтээр хийлгэж буй оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож  
доогуур нь зурах)-ын нэр:

.....  
.....

Өөрийн хүсэлтээр хийлгэж буй оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож  
доогуур нь зурах)-ний үр дүн (эмнэл зүйн туршлагын дүн, нотолгоонд тулгуурлан бүрэн  
эдгэрэлт, сайжралт, эндэгдэл, хүндрэлийн магадлалыг хувиар илэрхийлэн  
ойлгомжтойгоор тайлбарлана):

.....  
.....

Гарч болох эрсдэлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....  
.....

Гарч болох хүндрэлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....  
.....

Тухайн оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ний үед хийгдэж болох нэмэлт ажилбаруудыг нэг бүрчлэн дурьдана:

.....  
.....

Тухайн оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ыг орлуулж болох эмчилгээний бусад аргуудыг дурьдана:

.....  
.....

Санал болгож буй оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ний давуу тал:

.....  
.....

Санал болгож буй оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ний үед хийгдэж болох мэдээгүйжүүлэлт:

- Ерөнхий
- Нугасны мэдээ алдуулалт
- Хэсгийн мэдээ алдуулалт
- Тайвшруулах

Үйлчлүүлэгчээс тавьсан асуулт:

.....  
.....

Дээрх асуултын хариулт (товч):

.....  
.....

Эмчтэй холбоо барих утас: .....

Би үйлчлүүлэгчдээ дээрх мэдээллүүдийг дэлгэрэнгүй, энгийн ойлгомжтой үгээр тайлбарлаж өгсөн болно.

Эмчийн гарын үсэг \_\_\_\_\_ / .....

нэр



Б/ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ:

[ ] Миний хүсэлтээр хийж буй оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-ний талаар эмчийн өгсөн дараах мэдээллүүдийг БИ ОЙЛГОСОН.

Иймд.....

хийлгэхийг ЗӨВШӨӨРЧ БАЙНА.

[ ] Эмчийн санал болгосон оношилгооны ажилбар/эмчилгээ (аль нь болохыг сонгож доогуур нь зурах)-нээс гадна

.....  
.....

зэрэг нэмэлт ажилбар болон орлуулах эмчилгээ нь зөвхөн миний амь насыг аврах болон миний биеийн байдлыг муудахаас сэргийлэхийн тулд хийнэ гэдгийг БИ ОЙЛГОЖ БАЙНА.

[ ] Харин дараах ажилбаруудыг ХИЙЛГЭХИЙГ БИ ЗӨВШӨӨРӨХГҮЙ БАЙНА.

.....  
.....

Үйлчлүүлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../

Нэр

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../

нэр

Үйлчлүүлэгчтэй холбоотой эсэх: \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:

[ ] Насанд хүрээгүй

[ ] Ухаангүй

[ ] Сэтгэцийн эмгэгтэй

[ ] Бусад (тайлбарлана уу).....

Хэрэв өвчтөн жирэмсэн тохиолдолд:

Миний эхнэрийн хийлгэхээр зөвшөөрсөн мэс заслын хагалгааг би мөн зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../

нэр

Хэрэв нөхөр (асран хамгаалагч/харгалзан дэмжигч) нь зөвшөөрөөгүй бол тайлбарлана уу:

.....  
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудасны загварыг 2 хувь үйлдсэн болно.

огноо: \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_

Маягт 5

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС  
ТАТГАЛЗСАН ТУХАЙ МЭДҮҮЛЭГ

(Өвчтөний түүх/иргэний эрүүл  
мэндийн дэвтэрт хавсаргана)

Үйлчлүүлэгч \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ би эмнэлгийн тусламж  
үйлчилгээнээс татгалзах нь ямар үр дагавартай болох тухай мэдээллийг эмчээсээ авсан  
боловч уг эмчилгээ үйлчилгээнээс ТАТГАЛЗАЖ БАЙНА.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзаж буй шалтгаан:

.....  
.....

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзснаар миний биед гарч болох  
хүндрэлүүдийн талаар дараах МЭДЭЭЛЛИЙГ БИ АВСАН.

.....  
.....

[ ] Дээр дурьдсан хүндрэлийн жагсаалт нь бүрэн бус гэдгийг БИ ОЙЛГОЖ БАЙГАА  
бөгөөд хэрвээ би хүссэн тохиолдолд нэмэлт мэдээлэл авч болно гэдгийг МЭДЭЖ  
БАЙНА.

[ ] Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзсанаас гарч болох үр дагаварт эмчлэгч  
эмч, эмнэлгийг буруутгахгүй.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ / ...../  
Нэр

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг/ \_\_\_\_\_ / ...../  
нэр

Үйлчлүүлэгчтэй холбоотой эсэх: \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:

- [ ] Насанд хүрээгүй
- [ ] Ухаангүй /ухаан алдсан/
- [ ] Сэтгэцийн эмгэгтэй
- [ ] Бусад (тайлбарлана уу).....

Хэрэв жирэмсэн тохиолдолд;

Миний эхнэр дээрх эмчилгээ үйлчилгээнээс татгалзсныг би зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг \_\_\_\_\_ / .....

Нэр

Хэрэв нөхөр (асран хамгаалагч/харгалзан дэмжигч) нь зөвшөөрөөгүй бол тайлбарлана уу:

.....  
.....  
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудасны загварыг 2 хувь үйлдсэн болно.

огноо: \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_